



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Г

Г


“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжид баталгаажуулалт  
хийх төлбөрийн хэмжээ”-г шинэчлэн  
батлах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дах заалт, Стандарт хэмжил зүйн газрын Даргын 2019 оны А/56 дугаар тушаалаар баталсан “Бүтээгдэхүүн үйлчилгээний заавал баталгаажуулалтын ажлын төлбөр тооцоолох заавар”, тус хорооны 2019 оны 29 тоот тогтоолоор баталсан “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжид баталгаажуулалт хийх төлбөрийн хэмжээ”-г энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2015 оны 10 тоот тогтоол, 2016 оны 02 тоот тогтоол, 2016 оны 47 тоот тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.



Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн  
13 тоот тогтоолын  
хавсралт



## МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх) нь Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.3, Радио долгионы тухай хуулийн 20.3, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 14.3, MNS/ISO/IEC 17067:2014 “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн баталгаажуулалтын үндсэн асуудал ба бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн заавар” стандарт, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/56 тоот тушаалаар баталсан “Бүтээгдэхүүн, үйлчилгээний заавал баталгаажуулалтын ажлын төлбөр тооцоолох заавар”, Зохицуулах хорооны 2019 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”-ыг тус тус үндэслэн Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжид баталгаажуулалт хийх төлбөрийн хэмжээг тогтооно.

### Хоёр. Баталгаажуулалтын ажлын төлбөр

2.1 Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын төлбөрийг Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны А/56 дугаар тушаалаар батлагдсан “Бүтээгдэхүүн, үйлчилгээний заавал баталгаажуулалтын ажлын төлбөр тооцоолох заавар”-ыг үндэслэн дараах томъёогоор тодорхойлно.

$$B_{\text{толбөр}} = B_{BB(0) \text{хүн өдөр}} * P_{\text{хөдөлмөр зарцуулалт}}$$

Үүнд:  $B_{\text{толбөр}}$  -Баталгаажуулалтын төлбөр  
 $B_{BB(0)}$  -Нэг хүн өдрийн зардал  
 $P_{\text{хөдөлмөр зарцуулалт}}$  -Нийт хөдөлмөр зарцуулалт

2.2 Нэг хүн өдрийн зардлыг ( $B_{BB(0) \text{хүн өдөр}}$ ) дараах томъёогоор тодорхойлно.

$$B_{BB(0) \text{хүн өдөр}} = T * (1 + (K_{ш} + K_3) / 100) * (1 + A / 100)$$

Үүнд:  $B_{BB(0)}$  – нэг хүн-өдрийн зардал  
 $T$  – шинжээчийн нэг өдрийн ажлын хөлс, (70,857 төгрөг)  
 $K_{ш}$  – үйлчилж байгаа хуулиар цалинд тогтоосон шимтгэл, (12.5%)  
 $K_3$  – шууд зардлын нийт зардалд эзлэх хувь, (39%)  
 $A$  - Ашгийн түвшин, (7%)

$$B_{BB(0)} = 70857 * (1 + (12.5 + 39) / 100) * (1 + 7 / 100) = 70857 * 1.515 * 1.07 = 114,862 \text{ төгрөг}$$

**Хүснэгт 1. Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийг баталгаажуулах ажлын төлбөрийн хэмжээ**

Схемийн дугаар	1a	1б	2	3	4	5	6	7
<i>P<sub>хөдөлмөр зарцуулалт</sub></i>	7.0	6.0	6.6	7.6	8.6	9.6	7.6	4.0
<i>B<sub>ББ(т)</sub></i>	114,862	114,862	114,862	114,862	114,862	114,862	114,862	114,862
<i>B<sub>төлбөр (т)</sub></i>	<b>804,034</b>	<b>689,172</b>	<b>758,089</b>	<b>872,951</b>	<b>987,813</b>	<b>1,102,675</b>	<b>872,951</b>	<b>459,448</b>

2.3 Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийг баталгаажуулах нийт хөдөлмөр зарцуулалтыг “MNS ISO/IEC 17067:2014 “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн баталгаажуулалтын үндсэн асуудал ба бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн заавар стандарт”, “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”-ыг үндэслэн дараах схемээр тодорхойлно.

**Хүснэгт 2. Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжид тохирлын үнэлгээ хийх хөдөлмөр зарцуулалт /хүн-өдөр/**

№	Хийгдэх ажил	Схемийн дугаар							
		1a	1б	2	3	4	5	6	7
1	Баталгаажуулалтын өргөдөл хүлээн авч, иж бүрдэл шалгах	1.0	1.0	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.5
2	Баталгаажуулалтын өргөдөлд хавсаргасан баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх			1.0	1.0	1.0	1.0	1.0	
3	Баталгаажуулалтын схем сонгох, үнэлгээний удирдамж боловсруулах, батлуулах	1.0	1.0	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
4	Загварын дээж авах, сорилт туршилтанда хамруулах	2.0	-	1.0	1.0	1.0	1.0	1.0	-
5	Техникийн баримт бичиг, сорилтын тайланда дүн шинжилгээ хийж тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлэх	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0
6	Танилцуулга, дүгнэлт бэлтгэж баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0
7	Тохирлын гэрчилгээ хэрэглэх гэрээ байгуулах, тохирлын гэрчилгээ, тохирлын тэмдэг олгох	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0
8	Багц бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгох	-	1.0	-	-	-	-	-	-
9	Зах зээл дээрээс дээж авч сорилт, хяналт хийх	-	-	1.0	-	1.0	1.0	-	-
10	Үйлдвэрээс дээж авч сорилт, хяналт хийх	-	-	-	1.0	1.0	1.0	-	-

11	Үйлдвэрлэл, үзүүлж буй үйлчилгээ, явуулж буй үйл явцад үнэлгээ хийх	-	-	-	1.0	1.0	1.0	1.0	-
12	Гэнэтийн сорилт буюу хяналт хийхийг удирдлагын тогтолцооны аудиттай хамтатгах	-	-	-	-	-	1.0	1.0	-
	Нийт хөдөлмөр зарцуулалт /хүн-өдөр/	7.0	6.0	6.6	7.6	8.6	9.6	7.6	4.0

2.4 Баталгаажуулалтын схемийг ашиглах зааврыг хүснэгт 3-д үзүүлэв.

#### Хүснэгт-3. Баталгаажуулалтын схемийг ашиглах заавар

Схемийн дугаар	Ашиглах заавар
1A	Магадлан хяналт шаардлагагүй импортын тоног төхөөрөмжийн загварын дээжийг авч баталгаажуулах үйл ажиллагаанд ашиглана.
1Б	Магадлан хяналт шаардлагагүй импортын тоног төхөөрөмжийн багцыг баталгаажуулах үйл ажиллагаанд ашиглана.
2	Дотоодын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, тоног төхөөрөмжийн дээжийг авч магадлан хянаж баталгаажуулах үйл ажиллагаанд ашиглана.
3	Зах зээлээс тодорхой хугацааны давтамжтайгаар импортын болон дотоодын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн загвар дээжийг авч магадлан хянаж баталгаажуулах үйл ажиллагаанд ашиглана.
4	Үйлдвэрлэл болон зах зээл дээрээс тодорхой хугацааны давтамжтайгаар дотоодын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн дээжийг авч магадлан хянаж баталгаажуулах үйл ажиллагаанд ашиглана.
5	Үйлдвэрлэлийн үйл явц, удирдлагын тогтолцооны аудит болон зах зээл дээрээс тодорхой хугацааны давтамжтайгаар дотоодын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн дээжийг авч магадлан хянаж баталгаажуулах үйл ажиллагаанд ашиглана.
6	Тодорхой хугацааны давтамжтайгаар дотоодын үйлчилгээ, удирдлагын тогтолцооны аудит, үйл явцыг баталгаажуулах үйл ажиллагаанд ашиглана.
7	Магадлан хяналт шаардлагагүй, тоног төхөөрөмжийн загварын дээж шаардлагагүй, техникийн үзүүлэлт, сорилт туршилтын үр дүнг Монгол Улсад харилцан хүлээн зөвшөөрөх талаар хоёр талт болон бүс нутаг, олон улсын хэлэлцээрт гарын үсэг зурсан гадаад орны ижил төрлийн байгууллагаас олгосон загварын туршилтын гэрчилгээ, итгэмжлэгдсэн лабораторын сорилтын дүнтэй импортын тоног төхөөрөмжийг баталгаажуулах үйл ажиллагаанд ашиглана.

2.5 Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын тохирлын гэрчилгээг сунгах төлбөрийн хэмжээг баталгаажуулалтын байгууллагын 1 хүн-өдрийн зардалд үндэслэн тогтооно.

**Хүснэгт 4. Баталгаажуулалтын тохирлын гэрчилгээг сунгах төлбөрийн хэмжээ**

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Төлбөрийн хэмжээ /төгрөг/
1	Баталгаажуулалтын тохирлын гэрчилгээний сунгалтын төлбөр	тоног төхөөрөмжийн 1 загвар	114,862

2.6 Баталгаажуулалтын зөвлөлийн орон тооны бус гишүүнээр ажилласан гадны байгууллагын төлөөлөлд олгох хуралд оролцсон ажлын хөлс.

**Хүснэгт 5. Баталгаажуулалтын зөвлөлийн орон тооны бус гишүүний ажлын хөлс**

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Ажлын хөлсний хэмжээ /төгрөг/
1	Баталгаажуулалтын зөвлөлийн орон тооны бус гишүүдийн ажлын хөлс	1 хурал	50,000

2.7 Тохирлын гэрчилгээнд бичигдсэн мэдээллийг хүсэлт гаргагчаас шалтгаалан засварлаж дахин хэвлэх тохиолдолд гэрчилгээ тус бүрийн үнэ 15,000 төгрөг байна.

---Оо---